

ГАЗРЫН БАЯЛГИЙН ӨГӨӨЖӨӨР ХӨГЖЛИЙН ОРГИЛД ТЭМҮҮЛЖ БУЙ КАТАР ОРОН

*Г.Нинжин**

***Abstract:** Qatar, a country rich in oil and natural gas reserves, is one of the top five richest countries in the world. A poor “little” country under an external control until the middle of the last century, Qatar became a so-called rentier state due to its natural resources. Being more and more powerful regionally and globally, Qatar has been recognized today as the ‘middle’ power in a global political system. The vision of its further development is to substitute oil dependent economy for a sustainable and knowledge-based one. For that, they have released “Qatar National Vision 2030” in 2008, since then undertaking a wide range of reforms in each of the socio-political, economic and environmental sectors analysed on this paper. Thereby, a major focus is given to the sustainability issue of the Qatar’s development, derived from its national features, for which country is striving for.*

***Key words:** Natural resources, rentier state, allocation state, economic crisis, sustainable development, Qatar, Persian Gulf*

* * *

1970, 1980 оны үед Ойрхи Дорнод төдийгүй олон улсад газрын баялаг дээр “туйлсан”, “хэврэг” засаглалтай улс орнуудын тоонд орж байсан¹⁰⁶ Персийн булангийн Катар, Бахрайн, Оманы султант улс, Кувейтийн эмирт улс, Арабын нэгдсэн эмират улс болон Саудын Арабын вант улсууд нь 30 гаруйхан жилийн дотор бүс нутагтаа геополитикийн хүчирхэг төв, олон улсад нөлөө бүхий тоглогч эвсэл болж чаджээ.¹⁰⁷ Хэдийгээр тэд өөрсдийгөө “Булангийнхан” хэмээн тодорхойлж бүс нутагтаа бусдаас ялгардаг ч улс тус бүр өөрийн улс төр, нийгэм, эдийн засгийн онцлогтой хөгжиж иржээ.¹⁰⁸

Эдгээр дундаас Катар улс нь газар нутгийн хувьд 11,437 км² (Архангай аймгийг даруй 5 хуваасантай тэнцэх хэмжээний) “жижиг” улс хэдий ч Ойрхи Дорнодын бүс нутагтаа улс төрийн хамгийн нөлөө бүхий хүчнүүдийн нэг төдийгүй олон улсад ч их гүрнүүдтэй сайн түншийн харилцаатай, энх тайванч, төвийг сахисан улсын имижийг бүрдүүлж чадсан, “дунд” гүрний статусанд хүрсэн цөөн “жижиг” улсуудын нэг юм.¹⁰⁹ Улс төрийн тогтолцооны хувьд хэмжээлшгүй эрхт хаант засаглалын уламжлалт тогтолцоотой байсан тус улс нь шинэ зууны эхээр үндсэн хуульт хаант засаглалын тогтолцоо руу шилжсэн бөгөөд улсыг удирдагч хийгээд

* МУИС, ОУХНУС-ийн докторант

¹⁰⁶ Perthes, V. 2005. Die Golfmonarchien Licht aus dem Osten? In: Geheime Gärten. Die Neue Arabische Welt, p. 348. Bonn: Bundeszentrale für politische Bildung

¹⁰⁷ Нинжин, Г. 2014. Ойрхи Дорнодын Геополитикийн асуудалд: Бүс Нутаг дахь Хүчний Шинэ Төв Персийн Булан ба Монгол Улсаас Бүс Нутагт Баримтлах Улс Төрийн Байр Суурь, тал 56. Магистрын зэрэг горилсон бүтээл, МУИС, ОУХНУС.

¹⁰⁸ Perthes, V. 2005. Die Golfmonarchien Licht aus dem Osten? In: Geheime Gärten. Die Neue Arabische Welt, p. 349. Bonn: Bundeszentrale für politische Bildung

¹⁰⁹ Cooper, Andrew F. 2015. Middle Powers: Squeezed out or Adaptive? Public Diplomacy Magazine.

засгийн эрхийг баригч эмирээс сонгуульт 35 суудлын танхимтай улсын зөвлөх ассемблей болон бусад бүх төрийн захиргааны нэгжүүд бүгд исламын эрх зүйн үндэс болох *Шариа* хуулинд захирагддаг байна.¹¹⁰ Энэхүү шашин төрийн хосолмол тогтолцоо нь Ойрхи Дорнодын бүс нутгийг тодорхойлогч гол хүчин зүйл билээ.

Газарзүйн хувьд Катар улс өмнөд талаараа бүс нутгийн шинэ тэргүүлэгч хүчин Саудын Арабтай хиллэж, бусад талаараа Персийн булангаар хүрээлэгдэн оршдог. Энэ нь тус улс геополитикийн хувьд хүчирхэг, том улсын дарамт, нөлөөн дор оршин байдгийг илтгэнэ. Түүнчлэн Персийн буланд газрын тос, шатагч хийн арвин нөөц тогтоогдсон цагаас хойш тус бүс нутаг дэлхийн стратегийн чухал бүс, хүчирхэг гүрнүүдийн ашиг сонирхол огтлолцох төв цэг болон хувирсан байдаг.¹¹¹

Эдийн засгийн хувьд Катар улс зуу орчим жилийн турш Английн харьяанд голчлон сувдны наймаа эрхэлдэг ядуу буурай орон байсан бол өнөөдөр газрын тос, шатагч хийн нөөц баялгаараа дэлхийд 3 дугаарт жагсаж 2007 оноос хойш өнөөг хүртэл нэг хүнд ноогдох орлогын хэмжээгээр дэлхийд тэргүүлэгч улс, хүний хөгжлийн индексээр арабын ертөнцөд нэгдүгээр байр, дэлхийн хэмжээнд 1997 онд 57 дугаар байрнаас 2012 онд 36 дугаарт болж дээшэлсэн байна. Ийнхүү Катар улс хөгжлийн түлхүүр үзүүлэлтээрээ дэлхийн шилдэг таван улсын тоонд багтах болов.¹¹² Түүнчлэн тус улс 2010, 2011 онуудад өрнөсөн Арабын хаврын их үймээний үеэр дотооддоо амар амгалан байсан цөөн орнуудын нэг байв.¹¹³

Бахдам энэ амжилтаа бэхжүүлэхийн тулд Катарын төр засаг нэг талаас эдийн засгийн тогтвортой хөгжил хийгээд ард түмнийхээ элбэг хангалуун байдал, үүний дотор ялангуяа залуу хойч үе рүүгээ чиглэсэн эрүүл мэнд, боловсролын тогтолцоог улам боловсронгуй болгох, нөгөө талаас өсөн нэмэгдэж буй хүн амын нягтаршилтай холбоотой улсын дэд бүтцийн салбарыг өргөжүүлж хөгжүүлэх чиглэлийн бодлогод тус тус түлхүүр анхаарч байна.¹¹⁴

Ийнхүү тус улсын хөгжлийн жишээ нь зөвхөн газрын баялагтай хөгжиж буй улс орнуудын анхаарлыг татаад зогсохгүй дэлхийн тогтвортой хөгжил судлалын салбарт нэгэн сонирхолтой судлагдахуун болох магадлалтай юм. Эх газрын зүрхэнд орших газрын баялагийн арвин нөөцтэй манай улсын хувьд хэдий улс төр, нийгмийн тогтолцоо харилцан адилгүй ч Катарын хөгжлийн замнал, түүний туршлага хийгээд цаашдын бодлогыг сонирхож судлууштай билээ. Энэхүү өгүүлэлт Катар улсын жишээн дээр газрын баялгийг хэрхэн улс орны хөгжлийн үндсийг бүрдүүлэхэд ашиглаж буй хийгээд дэлхийн түүхийн эдийн хямрал, үнийн хэлбэлзэл зэргээс авсан сургамж ба цаашид тогтвортой хөгжихийн тулд тус улс ямар бодлого баримтлах болсон талаар тоймлон хүргэхийг хичээв.

¹¹⁰ United States Department of State Country Reports on Human Rights Practices for 2011: <http://www.state.gov/documents/organization/186656.pdf>

¹¹¹ Нинжин, Г. 2014. Ойрхи Дорнодын Геополитикийн асуудалд: Бүс Нутаг дахь Хүчний Шинэ Төв Персийн Булан ба Монгол Улсаас Бүс Нутагт Баримтлах Улс Төрийн Байр Суурь, тал 32. Магистрын зэрэг горилсон бүтээл, МУИС, ОУХНУС.

¹¹² Qatar Human Development in http://www.un.org/en/ecosoc/newfunct/pdf14/qatar_nr.pdf

¹¹³ Qatar: Rise of an Underdog in <http://politicsandpolicy.org/article/qatar-rise-underdog>

¹¹⁴ Qatar Human Development in http://www.un.org/en/ecosoc/newfunct/pdf14/qatar_nr.pdf

Хөгжилд хөтөлсөн түүхэн замнал

Арабын хойгийн улсуудын эртний түүх чулуун зэвсгийн үеэс эхтэй бол VII зуунд тус нутагт аж төрж байсан омгууд исламын шашинд нэгдэж эхэлснээр XVIII зуун хүртэл үргэлжилсэн исламын шашны эртний болон хожуу үе тус тус үргэлжилнэ. Катар улсын хувьд 1821 онд Бахрайны ноёрхлыг нухчин дарж Аль Тани гэр бүл засгийн эрхэнд гарснаар анхны бие даасан нэгж улсын зохион байгуулалтад орсон байдаг. Тус улсын XX зуун хүртэлх улс төрийн түүх бүс нутагт ноёрхлоо тогтоож байсан Бахрайн, Сауди, Оттоман, Англи зэрэг улсуудтай эвсэж харьяанд нь орох эсхүл дайсагнаж тусгаарлах зэрэг үйл явцаар тодорхойлогддог.¹¹⁵

Эдийн засгийн хувьд Персийн булан XX дугаар зууны эхэн хүртэл голчлон сувд, загасны наймаа эрхэлдэг харьцангуй бие даасан вант улсууд болон хөгжиж ирсэн нийтлэг түүхтэй. Тэдгээрийн Шейх буюу удирдагч нар нь дангаар бус томоохон худалдаачин гэр бүлүүдтэй хамтарч төр барьдаг байсан буюу худалдаачин гэр бүлүүдэд тодорхой хэмжээний улс төрийн эрх мэдлийг олгосны хариуд тэд санхүүгийн дэмжлэг авч эрх мэдлээ бэхжүүлдэг тогтолцоотой байжээ.¹¹⁶

Харин Катар улсын өнөөгийн оргилд хүрсэн хөгжлийн суурь XX дугаар зууны хагас буюу 1939 онд тус улсад анхны газрын тосны нөөц илэрснээр тавигдсан гэж хэлж болно. Гагцхүү газрын тосны олборлолт өргөн хэмжээгээр Дэлхийн II дугаар дайны дараа 1950-иад онуудад хийгдэж эхэлсэн бөгөөд үр дүнд нь тус улсын эдийн засаг, нийгэм, улс төрд томоохон өөрчлөлтүүд гарч эхэлсэн байна. Үүнийг илтгэх анхны томоохон үйл явдал бол 1979 оны 9 дүгээр сарын 1-нд Аль Тани гэр бүл Английн харьяанаас гарах улс төрийн тэмцэлийг үр дүнд засгийн бүрэн эрхийг гартаа авч тусгаар тогтнолоо зарласан явдал байв.¹¹⁷ Гэвч газрын баялгаас орж ирэх гэнэтийн их мөнгөний урсгал тус улсад томоохон сорилтуудыг авчирсан бөгөөд өнөөгийн хөгжлийн түвшинд хүрэх хүртэлх зам тийм ч дардам байгаагүй аж.

Газрын баялгийн хүчин зүйл

Газрын баялаг бол зөвхөн Катар бус Арабын хойгийн дийлэнх улс орнуудын улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжлийн түлхүүр хүчин зүйл нь мөн бөгөөд одоо ч хэвээр байна. Тусгаар тогтнолоо зарлаад удаагүй байсан засгийн эрх баригчын эрх мэдэл гадаадын газрын тосны нийгэмлэгээс хүртэх ашиг нэмэгдэх хэрээр хүчирхэгжин тэлж, улмаар газрын тосны ундаргыг төрдөө бүрэн өмчилж авсан байдаг. Үр дүнд нь 70-аад оноос эхлэн тус улсын сан хөмрөгт газрын тосноос орж ирэх орлого шууд орох болжээ.¹¹⁸ Ийнхүү газрын баялгийн өгөөжөөр зөвхөн Катар төдийгүй Арабын хойгийн дийлэнх орнууд улс төр, эдийн засгийн хувьд бүрэн бие даасан бөгөөд энэ цагаас тэдгээрийн улс орноо төвхнүүлж хөгжүүлэх үндэс тавигдсан хэмээн үзэж болох юм.

¹¹⁵ Qatar Webster's Timeline History 673 BC - 2007

¹¹⁶ Perthes, V. 2005. Die Golfmonarchien Licht aus dem Osten? In: Geheime Gärten. Die Neue Arabische Welt, p 350. Bonn: Bundeszentrale für politische Bildung

¹¹⁷ Qatar Webster's Timeline History 673 BC - 2007

¹¹⁸ Ibid.

Баялгийн сан нэмэгдэх хэрээр эдгээр орнуудын улс төр, нийгмийн салбарт гарах болсон нийтлэг шинжтэй гол өөрчлөлтүүдийг судалж үзэхэд: эрх баригч нь татварын орлогоос хараат бус болсноор харилцан хамааралтай байсан нийгмийн бүлгүүд, нэн ялангуяа хүчирхэг худалдаачин гэр бүлүүдийн нөлөөнөөс ангижирч, татварын тогтолцоог бүрэн бие даан шинэчлэх таатай орчин бий болжээ. Ингэснээр тэд жинхэнэ утгаар “хуваарилагч улс”¹¹⁹ болон хувирсан юм. Ийм төрлийн улс нь түүхий эдийн экспорт эсхүл ямар нэгэн монопольчлогдсон салбараас их хэмжээний орлого олж, түүнийгээ улс төрийн таатай орчин бүрдүүлэх зорилгоор ард олондоо хуваарилан тараадаг байна.¹²⁰ Өөрөөр хэлбэл, эдгээр улс нь ард иргэддээ санхүүгийн дарамт учруулдаг тогтолцоог халж, эсрэгээр ард түмнээ “тэтгэгч улс” болон хувирсан байдаг.¹²¹ Гагцхүү үйлвэрлэл, үйлчилгээ буурай хөгжсөн улс орнуудын хувьд гадаад экспортынх нь цар хүрээ голчлон түүхий эдээр хязгаарлагдах бөгөөд зах зээлийн глобал систем энэхүү үзэгдлийг улам бүр өөгшүүлдэг аж.¹²² Ийм ч учраас ХХ дугаар зууны эцэс хүртэл эдгээр улсуудын орлогын 70 – 95 хүртэлх хувийг дан ганц газрын тосны экспорт бүрдүүлж байв. Хэмжээлшгүй эрхт хаант засаглалтай учир Шейхийн гэр бүлд энэхүү орлогыг захиран зарцуулах бүрэн эрх төвлөрөх бөгөөд ингэхдээ тэд улс орны эдийн засгийн үр ашгийг тооцох бус нэн тэргүүнд улс төрийн эрх мэдлээ хадгалан хамгаалахыг чухалчилдаг байжээ. Ийм ч учраас тэдний томоохон худалдаачин гэр бүлүүд болон татварын орлогоос хараат бус болсон явдал нь эрх баригчдыг бүрэн эрх ямба эдэлж ард олныхоо ашиг сонирхлыг үл тоомсорлох бус, харин ч ард түмнийхээ буюу нийгмийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулах томоохон эрх чөлөө, орон зайг бүрдүүлж өгсөн гэж хэлж болох юм. Энэ төрлийн “тэтгэгч улс” нийгэмтэйгээ дараах үндсэн зарчмын дагуу гэрээлсэн байх аж:

Үүнд эрх баригч тал

- нийгэм, ард иргэдийн аюулгүй байдлыг хангах;
- нийгмийн баталгааг өгөх;
- хангалуун амьдралыг бүрдүүлэх;
- тодорхой хэмжээнд улсад төвлөрөх газрын тосны ашиг хүртээх, харин үүний хариуд ард түмэн буюу нийгэм;
- эрх баригчдын эрх мэдлийг хүлээн зөвшөөрөх;
- эдгээр нь илт дампуурах эсвэл гэрээний хэсгүүдийг зөрчихөөс нааш улс төрийн аливаа шаардлага тавьдаггүй байв.¹²³

¹¹⁹ Англи хэлнээ allocation state эсхүл rentier state гэх энэхүү улс төр судлал болон олон улсын харилцаан дахь онолын ойлголтыг анх 1970 онд Хосейн Махдави өөрийн "The Pattern and Problems of Economic Development in Rentier States: The Case of Iran", in *Studies in the Economic History of the Middle East*, ed. M.A. Cook (Oxford University Press, Oxford 1970) бүтээлдээ танилцуулсан байдаг. Онолын үүднээс судлаачид энэ төрлийн улсыг дотор нь ангилж үздэг. Тухайлбал, Peter Pawelka өөрийн „Der Vordere Orient und die internationale Politik“ (Stuttgart, 1993) бүтээлдээ улсын орлогын талаас дээш хувийг түүхий эдийн экспортоос бүрдүүлдэг улсыг бүрэн тэтгэгч, дор хаяж тавныг нэгийг бүрдүүлдэг улсыг хагас тэтгэгч улс хэмээн ангилсан байдаг.

¹²⁰ Ruf W., Marx Ch. 2012. Wandel in der arabischen Welt, p. 58. LIT Verlag Münster

¹²¹ Perthes, V. 2005. Die Golfmonarchien Licht aus dem Osten? In: Geheime Gärten. Die Neue Arabische Welt, p 351. Bonn: Bundeszentrale für politische Bildung

¹²² Singer (1950) in Perthes, V. 2005. Die Golfmonarchien Licht aus dem Osten? In: Geheime Gärten. Die Neue Arabische Welt, p 351. Bonn: Bundeszentrale für politische Bildung

¹²³ Perthes, V. 2005. Die Golfmonarchien Licht aus dem Osten? In: Geheime Gärten. Die Neue Arabische Welt, p 351. Bonn: Bundeszentrale für politische Bildung

Харин аливаа сөрөг хүчин төрөн гарвал эрх баригч тал ихэвчлэн түүнийг худалдан авах замаар өөрийн эгнээнд элсүүлэн хамтрагчид болдог байжээ.

Ийнхүү Персийн булангийн улсууд тэтгэгч улс болсноор ард иргэд, хувийн хэвшил хоёр нь төрөөс хараат болж хувирсан байна. Эрх баригчийн ард олондоо мөнгө хуваарилсан болон тэдэнд баялгийн баталгаа олгож ирсэн суваг нь олон янз байв. Тухайлбал,

- Газар худалдан авах хөтөлбөр: ашиглагддаггүй газрыг улс өндөр үнээр худалдан аваад, газар тариалангийн газар болгон зарлах буюу газар тариалан эрхлэх боломжтой болгоод буцаан хямд үнээр нутгийн иргэдэд худалддаг;
- Үйлчилгээний салбарт төрөөс үзүүлэх санхүүгийн тэтгэлэг;
- Импортын монополчлолыг хуваан хуваарилах;
- Гадны аж ахуйн нэгжүүд, ажилчид дотоодын спонсортой заавал хамтран ажиллах, тэрхүү спонсор нь компанийн буюу ашгийн 51% эзэмших эрх зүйн зохицуулалт зэргийг дурдаж болох юм.¹²⁴

Улмаар 70-аад оны газрын тосны экспортын оргил үеэр эдгээр улс орнуудад нэг хүнд ноогдох орлогын хэмжээ барууны орнуудын түвшинд хүрсэн нь ард түмний хэрэглээний эрэлт эрс өөрчлөгдөхөд хүргэж ялангуяа дэд бүтэц хийгээд зэвсэгт хүчний салбарт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэхэд хүргэв. Нөгөө талаар хамгийн үнэтэй, хамгийн чанартайг хэрэглэх гэсэн эрэлт хэрэгцээ барууны орнуудаас боловсон хүчний хийгээд бараа таваарын хараат байдалд оруулав. Түүнчлэн эдгээр орнуудыг гадны ажилчдын импортлогч орон болон хувиргажээ. Арабын бусад ядуу улс орнууд төдийгүй Пакистан, Энэтхэг, Филиппин болон бусад Азийн орнуудаас цагаач ажилчид ихээр ирж байсан нь газрын тосны баялгийг ялангуяа Арабын сул эдийн засагтай орнууд хүртэх замыг нээсэн байдаг (Египет, Йемен, Йордан, Сири г.м.). Улмаар гадны ажилчдын тоо нийт хүн амын тооноос давав. Хүн амын ийнхүү их нягтаршил нь төрийн захиргаа үйлчилгээний байгууллагуудын ажлын чадамжийг сайжруулж төр хувийн хэвшлийн үйлчилгээний байгууллагуудын холбоо хэлхээ хамтын ажиллагаа болон тэдгээрийн эдийн засгийн дэд бүтцийг нягтаршуулж сайжруулсан ач хобогдолтой байсан хэдий ч цагаач ажилчдын эрх зүйн орчин ихээхэн сул хөгжсөн байв. Тухайлбал, ажилчдын оршин суух зөвшөөрөл гаргуулах асуудал тухайн хөрөнгө оруулагч дотоодын этгээдээс шууд хамааралтай байсан ба үйлдвэрчний эвлэл мэтийн ажилчдын эрх ашгийг хамгаалах байгууллага байдаггүй хийгээд иргэншил олгох, нийгэмшүүлэх тал дээр нээлттэй бус бодлого хэрэгждэг байв. Гэсэн хэдий ч тэд эх орондоо авдаг цалингаа хэд нуглан авч ар гэртээ илгээх явдал өдгөө ч хүлээн авагч орнуудын эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулсаар байна. Хэдийгээр эдийн засагчид тус мөнгөний урсгалыг хүлээн авагч орондоо эргэн өгөөжөө өгөх аж үйлдвэр гэх мэт салбарт шингэдэггүй, ядуусын хороололд шинэ байр, хотхон үүсэх төдийд л зарцуулагдаж буйг шүүмжилдэг боловч ард иргэд хөрөнгө мөнгөө зарцуулахдаа эдийн засгийн үр ашгийг тэр бүр тооцдоггүй болохыг тус байдал илтгэнэ. Гагцхүү,

¹²⁴ Perthes, V. 2005. Die Golfmonarchien Licht aus dem Osten? In: Geheime Gärten. Die Neue Arabische Welt, p 352. Bonn: Bundeszentrale für politische Bildung

энэхүү мөнгөний урсгал нь хүлээн авагч буурай орнуудын ажилгүйдэл хийгээд хөдөлмөрийн зах зээл дээрх тулгамдаж буй асуудлуудыг саармагжуулахад эерэг нөлөө үзүүлдэг учир тэдгээрийн төр засаг илгээгч ажилчдынхаа урсгалыг хадгалах сонирхолтой байдаг аж.¹²⁵

Нөгөө талаар Катарчууд болон бусад эзэн орны иргэдийн хувьд ажил голох эрх ямба суух болж биеийн хүчний хийгээд бусад доогуур түвшний ажлыг ихэвчлэн гадны ажилчдаар хийлгэх сонирхол нэмэгдэх болжээ. Аливаа хүчнээс хараат бус авторитар засаглал бүхий тэтгэгч төр улсад ажиллах хангалттай хүчин гаднаас орж ирэх болсон явдал нутгийн ард иргэдийг байнга тэтгүүлж бэлэнчлэх “цамаан” сэтгэлгээ суухад нөлөөлсөн байдаг. Энэхүү сэтгэлгээ нь хойгийн улс орнуудын эдийн засгийн хөгжилд ч ихээхэн хохирол учруулсан байдаг. Үүнд иргэдийн боловсрол, өрсөлдөх чадвар, аж ахуйн нэгжүүдийн ашгийн төлөөх үндсэн зорилго хийгээд эрсдэл хүлээх чадвар зэрэгт сөрөг үр дагавар тус тус авчирсан юм. Тэд 1995 оны дэлхийн газрын тосны үнийн их уналт хүртэл улс орны эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвт санаа тавихаа орхигдуулж хэт тансаглалд умбаж байв.¹²⁶

Хямрал сургууль болсон нь

80-аад оны дундаас газрын тосны үнийн хэлбэлзэл Катар болон бусад хойгийн орнуудын төр засагт тодорхой сорилтуудыг авчрах болсон бөгөөд ялангуяа 90-ээд оны дунд үед дэлхийн газрын тосны хямрал нүүрлэсэн явдал тэдэнд томоохон цохилт болсон юм. Энэ үед газрын тосны үнэ сүүлийн 20 жилд байгаагүй доод цэгтээ хүрч¹²⁷, үүний уршгаар 85-аас 95 хувь газрын тосноос орж ирэх орлогоос бүрддэг байсан улсын төсөв ганцхан жилийн дотор ДНБ 15 хуртэлх хувиар буурав.¹²⁸ Энэ төрлийн алдагдал хүлээх нь зах зээлийн эдийн засаг хөгжсөн орнуудын улс төрийн хувьд төсөөлшгүй их уналт юм. Газрын тос олборлогч бүх улс орнууд хямралыг даван туулах өндөр сахилга бат бүхий бодлого баримтлаж төсвийн зарлагаа их хэмжээгээр хумих, төсвийн алдагдлаа гадаадаас өр зээл авч, гадаад дахь хөрөнгө оруулалтыг хумиснаар нөхөхийг оролдож байв. Үр дүнд нь 2000 онд газрын тосны үнэ сая олборлогч орнуудын хувьд боломжийн үнийн түвшинд хүрч чадсан аж.¹²⁹

Эл хямралаас хойш тухайн орны төр засаг өөрсдийн эрх мэдэл, тогтсон дэглэмийг хадгалан үлдэхийн тулд улс орны эдийн засгийн тодорхой хувийг хэрхэн ард иргэдийн нуруун дээр үрүүлэх тухай бодох болов. Өөрөөр хэлбэл, хямралын үр дагавраар улс орон, ялангуяа эрх баригч хэмжээлшгүй эрхт хаант засаглал бүтцийнхээ хувьд уян хатан, аливаа гадаад дотоод нөхцөлд дасан зохицох чадвартай болох, шаардлагатай шинэчлэлүүдийг хийх, үүгээр өмнө нь төдийлөн тоодоггүй байсан улс төр хийгээд нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүдэд анхаарлаа хандуулах шаардлага тус тус урган гарч ирэв. Түүнчлэн, эдийн засгийн

¹²⁵ Ali Khalifa al-Kawari. 1996. tanmiya li-l-diya ‘! Am diya’li-furas al-tan-miya. Muhassilat al-taghayyurat al-musahiba li-l-naft fi buldan majlis al-ta’awun [Алдагдалд хүргэсэн хөгжил! Юм уу хөгжих боломжыг алдсан явдал уу? ГХАЗ-ийн улс орнуудад газрын тосны үр дүнд гарсан өөрчлөлтүүдийн үр дагавар], Beirut

¹²⁶ Ibid.

¹²⁷ BP Amoco Statistical Review of World Energy 2000

¹²⁸ World Bank

¹²⁹ BP Amoco Statistical Review of World Energy 2000

тодорхой хувийг ард иргэдийн нуруунд үүрүүлснээр сөрөг хүчин сул хөгжиж ирсэн эдгээр тэтгэгч улс орнуудын хувьд эрх баригч гэр бүлийн эрх ашиг шууд хөндөгдөх ярвигтай нөхцөл үүсэхээр байв. Мөн глобалчлалын их давалгаа буюу дэлхий дахины техник, эдийн засгийн үсрэнгүй хөгжил, үр нөлөө, үүнтэй зэрэгцээд үндэсний үнэт зүйлээ хамгаалан хадгалах явдал хийгээд зөрчил ихтэй Арабын ертөнцдөө төдийгүй хувьсан өөрчлөгдөж буй олон улсын тавцан дахь байр сууриа бэхжүүлэн хөгжүүлэх зүй ёсны шаардлагууд тулгараад байв.¹³⁰

Эдгээр шаардлагуудыг даван туулахад хойгийн улс орон бүр харилцан адилгүй арга хэмжээ авсан түүхтэй. Эдгээр дотроос Саудын Араб хойгийн орнуудын хамгийн том хэмжээний газар нутаг эзлэх бөгөөд хамгийн нүсэр бүтэцтэйн хувьд аливаа өөрчлөлт шинэчлэл хийхэд цаг хугацаа, зардал мөнгөний хувьд төдийлөн амаргүй байсан бол Катар мэтийн “жижиг” улсын хувьд харьцангуй уян хатан байж оновчтой бодлогыг цаг алдалгүй явуулах давуу талтай байв.¹³¹ Түүнчлэн, Саудын Арабын нөлөөллөөс ангижрах, бүс нутаг төдийгүй олон улсад бие даасан бодлого бүхий нэгж улсын байр сууриа бэхжүүлэх замаар хямралыг боломж болгон хувиргах шинэ нөхцөл тус улсын хувьд үүсээд байв. Түүхэн энэ зааг дээр Катар эрх баригч шейхийн гэр бүл дотор эрх мэдлийн тэмцэл өрнөсөн ба 1972 оноос хойш улс орныг удирдаж ирсэн эмир шейх эцэг Аль-Таниг түүний төрсөн хүү Хамад бин Халифа Аль-Тани цусгүй тэмцлээр нухчин дарснаар 1995 онд засгийн эрхийг гартаа авсан юм.¹³²

Шинэ Эмир улс орноо илүү ардчилсан хийгээд иргэний нийгмийг илүү нээлттэй болгох эрмэлзэлтэй байгаагаа зарлаж либерал шинэчлэлийн бодлогыг эрчимтэй явуулж ирсэн байдаг. Онцлон дурдвал, 1996 онд пан Арабын мэдээллийн саттелит сүлжээ Аль Жазираг үүсгэн байгуулсан, 1999 онд орон нутгийн сонгуулийг эрэгтэй, эмэгтэй хүмүүс эрх тэгш оролцоотойгоор зохион байгуулсан, улс төрийн үйл ажиллагааг либералчилж үндсэн хуулиар¹³³ баталгаажуулсан зэрэг явдлуудыг нэрлэж болно. Түүнчлэн шинэ эмир гадаад бодлогодоо ихээхэн анхаарч Саудын Араб, Бахрейн улсуудтай хилийн уламжлалт зөрчил маргаанаа дипломат замаар шийдвэрлэж чадсан ба үүгээр цаашдын бүс нутгийн аливаа зөрчил маргаанд зуучлагчийг үүрэг гүйцэтгэх үүдийг нээж суурийг нь тавьсан гэж судлаачид үздэг.¹³⁴ Мөн тэрээр эхнэр шейха Мозахын хамт боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт ихээхэн ач холбогдол өгч ирсэн явдал тус салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээнээс тодорхой харагдана. Катар улс 2022 оны дэлхийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг эх орондоо зохион байгуулах эрхийг авч чадсан явдал тус улсын хөгжлийн түүхэнд томоохон үйл явдал байв. Түүнчлэн, тус улсын нийслэл Доха хот нь Арабын боловсролын шинэ төв болон хөгжиж ирсэн ба энд дэлхийн олон нэр хүнд бүхий их дээд сургуулиудын салбар үйл ажиллагаа явуулах болжээ.

¹³⁰ Perthes, V. 2005. Die Golfmonarchien Licht aus dem Osten? In: Geheime Gärten. Die Neue Arabische Welt, p 355. Bonn: Bundeszentrale für politische Bildung

¹³¹ Perthes, V. 2005. Die Golfmonarchien Licht aus dem Osten? In: Geheime Gärten. Die Neue Arabische Welt, p 356. Bonn: Bundeszentrale für politische Bildung

¹³² Qatar Webster's Timeline History 673 BC - 2007

¹³³ 2005 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж ирсэн (2013 онд нэмэлт өөрчлөлт орсон)

¹³⁴ Lambert J. 2011. Political Reform in Qatar: Participation, Legitimacy and Security. Middle East Policy Council

Үүнд, АНУ-ын алдартай Вэйл Корнеллийн анагаах ухааны коллеж, Техасын Эй энд Эм их сургууль, Карнеги Меллоны их сургууль, Жоржтауны их сургууль зэргийг нэрлэж болно. Мөн Катарын мэдээлэл, технологийн үндэсний паркад шилдэг компаниуд өндөр технологи бүхий шинэ бараа бүтээгдэхүүнүүд зах зээлд нэвтрүүлэхээр судалгаа хийх болжээ. Түүнчлэн тус улсын дэд бүтцийн хөгжилд Барууны компаниуд томоохон хэмжээний бүтээн байгуулалтыг хийж гүйцэтгэж буй юм. ХБНГУ-ын Дойче Баан компани Доха хотын метро сүлжээ болон тус улсыг Бахрайн, Саудын Арабтай холбосон холын тээврийн замыг тус тус бүтээн байгуулж байгаа аж.¹³⁵ Ийнхүү тус улс нь дэлхийн шилдэг ноухауг эх орондоо өндөр хурдаар нутагшуулах замаар газрын баялгаас хараат байдлаас ангижирч тогтвортой, мэдлэгт суурилсан эдийн засаг хөгжүүлэхийг зорьж буй юм.

Катарын засгийн газар эдийн засгийн өсөлтийн түвшинг нэг талаас улс орныхоо хэм хэмжээнд тохируулан барих, нөгөө талаас экологийн тогтвортой хөгжлийн чиг шугамыг баримтлан ажиллаж ирсэн байдаг.¹³⁶ Харин тус улсын ирээдүйн хөгжлийн чиг хандлага, зорилго зорилтуудыг тусгасан “Катарын үндэсний алсын хараа 2030” хэмээх бичиг баримтад тус улсын хэтийн хөгжилд боловсролын салбар хийгээд байгаль орчинд ээлтэй байх хандлага гэсэн хоёр чиглэл газрын баялгийн хүчин зүйлийг орлох хэмжээний чухал байр суурь эзлэх болсон тухай тусгагджээ.¹³⁷ Хүн ам нь тогтмол өсөн нэмэгдэж буй тус улс 2013 оны байдлаар 2 сая давсан үзүүлэлттэй байсан бөгөөд хүн амын дийлэнх хувийг 15-аас 24 насны залуучууд эзэлдэг байна.¹³⁸

Өдгөө Катар улс нь олон улсын тавцанд томоохон улс гүрнүүдийн ойрын итгэлт түнш орон бөгөөд “Катарын үндэсний хөрөнгө оруулалтын газар” гэх эрх бүхий байгууллагаараа дамжуулан төрөл бүрийн үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүдэд хувь нийлүүлэгчээр оролцдог байна. Түүхий эд тус улсын экспортын 92%-ийг, төсвийн ордогын 62%-ийг эзлэх бөгөөд газрын тосны нөөц 25 тэрбум баррель буюу олборлолтын дундаж хэмжээгээр үргэлжлүүлэн 56 жил олборлох боломжтой, шатагч хийн нөөц нь 25 триллон метр куб буюу дэлхийн нийт нөөцийн 13% дангаараа эзэмшдэг. Тус улсын ДНБ 2014 онд 320.5 тэрбум доллар, нэг хүнд ноогдох ДНБ мөн онд 143.400 доллар байжээ. ДНБ бүрдүүлж буй салбарууд нь газар тариалан 0.1%, аж үйлдвэр 68%, үйлчилгээ 31.9% юм. Түүнчлэн, мөн оны инфляцийн түвшин 3%, ажилгүйдлийн түвшин 0.4% буюу дэлхийд хамгийн бага ажилгүйдэлтэй улсуудын жагсаалтны хоёрдугаарт бичигдэж буй юм.¹³⁹

Тус улсын хөрөнгө оруулалтын орчин олон улсад маш сайн гэсэн үнэлгээтэй байдаг нь тус улсын

- хувь нийлүүлэгчийн тухай хууль маш тодорхой бөгөөд ойлгомжтой,
- хөрөнгө оруулалтын таатай хийгээд сонирхолтой орчин,

¹³⁵ Lublinski J. 2012. Katar klont Elite-Unis. Bild der Wissenschaft. http://www.wissenschaft.de/archiv/-/journal_content/56/12054/1630333/Katar-klont-Elite-Unis/

¹³⁶ Wirtschaft von Qatar in <http://botschaft-katar.de/wirtschaft/wirtschaft-von-katar/>

¹³⁷ "Qatar National Vision 2030". Ministry of Development Planning and Statistics

¹³⁸ National Development Planning and Implementation Human Development, Sustainable Development and National Well-being in Economic and Social Council Annual Ministerial Review 2014

¹³⁹ The World Factbook, Central Intelligence Agency.

- нийгэм ба улс төрийн тогтвортой байдал,
- гадны улс орнуудтай тогтвортой бөгөөд найрсаг харилцаатай байдаг явдал болон
- гео-стратегийн ач холбогдол бүхий байршилтай зэрэг хүчин зүйлстэй холбоотой аж.¹⁴⁰

Энэхүү эдийн засгийн хөгжлийн түвшинг бууруулахгүй хадгалан барихын тулд Катар улс гадна ба дотны хөрөнгө оруулалтыг дэмжих үүднээс эдийн засгийн уян хатан стратеги баримталдаг байна. Үүнд сайтар хөгжүүлсэн дэд бүтэц, аж үйлдвэрийн салбар дахь түрээсийн нэрлэсэн үнэ болон импортын машин тоног төхөөрөмжийн хураамжаас чөлөөлсөн зохицуулалт зэргийг нэрлэж болно. Түүнчлэн Катарын хөрөнгө оруулалтын тухай хууль нь гадны хөрөнгө оруулалтын татах, мөн хөрш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлэхэд таатай орчныг бүрдүүлээд зогсохгүй тус улсын эдийн засгийг аливаа хор хөнөөлтэй голдрилд орохоос хамгаалж байдаг аж. Катарын төв банк тус улсын санхүүгийн зах зээлийг зохион байгуулах, хянах, тогворжуулах зорилгоор Катарын үндэсний хөрөнгийн санг орлон анх 1993 онд байгуулагдсан байдаг. 1995 онд тус банк бодлогын хүүгээ либералчилснаар арилжааны банкууд хүүгийн дээд хэмжээг өөрсдөө тогтоодог болжээ. Катар улсад 37 банк үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнд дотоодын төдийгүй арабын болон бусад орны байгууллагууд багтана.¹⁴¹

Хэтийн хөгжлийн гол түлхүүр - мэдлэгт суурилсан эдийн засаг

Хөрөнгө мөнгөний нэн таатай орчинг ашиглан тус улсын тэргүүн эгнээнд тавьж буй зорилго бол эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах явдал юм. “Катарын үндэсний алсын хараа 2030” баримт бичигт тусгагдснаар энэхүү зорилгодоо хүрэхийн тулд харилцан хамаарал бүхий гурван үндсэн зорилт дэвшүүлсэн байх бөгөөд эдгээр нь тус улсын засгийн зүгээс баримтлах цаашдын гадаад болон дотоод бодлогыг тодорхойлох аж. Үүнд

- Катарчуудын амьдрал ахуйн стандартын өндөр түвшинг баталгаажуулах,
- инноваци болон бизнесийн чадамжийг сайжруулж, өргөжүүлэн тэлэх хийгээд
- эдийн засгийн үр ашигтай байдлыг улс орны эдийн засаг болон санхүүгийн аюулгүй байдлатай хослуулах зэрэг зорилтууд багтсан байна.¹⁴²

Эдгээр зорилтуудад хүрэхийн тулд “Үндэсний эдийн засгийн стратеги 2011-2016” баримт бичгийг боловсруулж баталсан байдаг. Үүнд дээрх зорилтуудад чиглэсэн хэд хэдэн төсөл тусгагдсан нь Катарын эдийн засгийг илүү тогтвортой илүү чинээлэг болгон өөрчлөн хувиргах учиртай ажээ. Тухайлбал

- Катарын бүтээмжийг суурь чадамжыг бэхжүүлэх,
- эдийн засгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх,
- техник технологийн ашигт байдлыг өсгөх,

¹⁴⁰ Wirtschaft von Qatar in <http://botschaft-katar.de/wirtschaft/wirtschaft-von-katar/>

¹⁴¹ Ibid.

¹⁴² "Qatar National Vision 2030". Ministry of Development Planning and Statistics

- эдийн засгийн солонгорох явцыг дэмжих зэрэг хөтөлбөрүүд багтсан байна.¹⁴³

Нарийвчлан авч үзвэл, бүтээмжийн суурь хөрс гэдэг нь макро эдийн засаг дахь түүхий эдийн нөөц, байгууллага аж ахуйн нэгжүүд, дэд бүтэц болон ажиллах хүчин бүгдийн нийлмэл үзүүлэлтийг хэлнэ. Энэхүү үзүүлэлт бүхий бүтээмжийн суурь чадамж хэдий чинээ хүчирхэг, бат бөх байна, төдий чинээ нийгмийн давхрага бүр хүртэх эдийн засгийн хүртээмж нэмэгддэг аж. Тус үзүүлэлтийг газрын тос, хийн баялаг дээр эдийн засаг нь оршин тогтнож буй Катар орны хувьд авч үзэхэд ашигт малтмалаас орж ирсэн ашгийг хасаад эдийн засгийн үр ашгийн үзүүлэлт 2009 оны байдлаар 9,2% алдагдалтай гарсан байна. Хэдийгээр жил ирэх тусам энэ хувь багассан үзүүлэлттэй байгаа ч дэлхийн эрчим хүчний зах зээлийн орчин үеийн шаардлагатай хөл нийлүүлэн алхадаг болохын төлөө засгийн газар нь зорьж ажиллаж буй юм.

Эдийн засгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх талбарт улс төрийн түвшинд хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлж буй бөгөөд үүнд улсын төсвийн тооцооллыг үр ашигтай хийгээд дэвшилттэй хийж хэвших, улсын төв банкны системийг шинэчлэх, олон нийтийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр хэрэгжүүлэх замаар олон нийт, хувийн хэвшил хоорондын хэлхээ холбоог сайжруулах, сангийн яамны зээлийн удирдлагын тогтолцоог бий болгох, төрөл төрлийн хөрөнгө оруулалт оруулах замаар санхүүгийн урсацыг сайжруулах зэрэг ажлууд ордог байна. Түүнчлэн, тогтолцооны түвшинд өгөгдөл нөөцийг үр ашигтай захиран ашиглах нь санхүүгийн амжилт болон бүтээмжид эерэг нөлөө үзүүлдэг нь батлагдсан тул Катар улс 2016 он хүртэл дэд бүтцийн хөгжилд зориулж 65 сая ам.доллар зарцуулсан байна. Үүнд усны нөөцийг сайжруулах, эрчим хүч зарцуулалтыг багасгах, тээвэрлэлтийн нөөцийн хэмжээ хийгээд далайн тээврийн сувгуудыг нэмэгдүүлэх, газар ашиглалтыг шинэчлэх гэх мэт ажлууд багтжээ.

Харин солонгорсон эдийн засгийн гол ач холбогдол нь ажлын байр нэмэгдүүлэхээс гадна хойч үедээ боломж бололцооны асар их нөөц боломжыг өвлүүлж буй явдал билээ. Энэ нь Катарын хувьд хэтдээ газрын тос буюу түүний үнийн хэлбэлзлийн хараат байдлаас ангижрах гол гарц нь болох аж. Энэ зорилгод хүрэхэд Катарын нийгэм хүн ард нь сэтгэлгээний хийгээд тогтолцооны олон үндсэн өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай хэмээн үздэг. Тухайлбал, ирж буй он жилүүдэд энтерпринёр соёлыг нэвтрүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргах болсон байна. Учир нь өнөөгийн байдлаар жижиг дунд бизнес эрхлэгчид эдийн засгийн ердөө 15%-ийг л эзэлж байна. Энэ талбарт эрчимтэй ахиц гаргах үүднээс “Энтерэпрайз Катар” санаачилгыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үүгээр төрөөс олгож буй бүтээмжид суурилсан санхүүгийн дэмжлэгийн хэмжээ болон өсөн дэвжихийг эрэлзэж буй аж ахуйн нэгжүүдийн тоог өсөн нэмэгдүүлэх зорилготой.¹⁴⁴

¹⁴³ Qatar National Development Strategy 2011-2016

¹⁴⁴ Wirtschaft von Qatar in <http://botschaft-katar.de/wirtschaft/wirtschaft-von-katar/>

Эрдэм шинжилгээг хөгжүүлэх нь

Катарын хөгжлийн бодлогын хүрээнд боловсон хүчний чадамжийн асуудал чухал байр эзэлж байна. Учир нь сүүлийн жилүүдэд ачаалал ихтэй боловч бага цалинтай ажлын байр олширсон явдал Катарчуудын хувьд ажил хөдөлмөр тогтвортой эрхлэх, ажлын байран дээрээ өсөн дэвших боломж хумигдахад хүргэж буй аж. Иймд өндөр боловсролтой Катарчуудын өсөн дэвших боломж бүхий ажлын байрны эрэлтийг хангах үүднээс судалгаа шинжилгээ, хөгжил дэвшлийн шинэ соёлыг нэвтрүүлж, улмаар гадны хөрөнгө оруулалтыг өөртөө татах нь чухал болоод буй юм. Эс бөгөөс эдгээр боловсон хүчин гадаадад эсхүл төрийн захиргаа үйлчилгээ, олон нийтийн салбарт ажиллахаас өөр сонголтгүй нөхцөл үүсэх юм. Тиймээс Катарын засгийн газар жил тутам ДНБ-ий 2,8% буюу ойролцоогоор 100 тэрбум ам.долларыг судалгаа, эрдэм шинжилгээний салбарт зарцуулах болжээ.¹⁴⁵ Тухайлбал, Катарын сан байгууллага нь боловсролын салбарыг иргэдэд илүү хүртээмжтэй болгох, мөн илүү мэдлэгт суурилсан бизнес орчинг бий болгоход гол чиглэлэлээ болгон ажиллаж байхад Катарын шинжлэх ухаан, технологийн парк нь уламжлалт судалгаа, шинжилгээний цар хүрээг давсан хамтын ажиллагааг эрхэмлэгч шинэлэг бөгөөд салбар дамнасан судалгааны хүрээлэн болон хөгжиж ирсэн байдаг. Энэхүү паркийн бүтээн байгуулалтад 300 сая ам.доллар зарцуулагдсан тухай тооцоо бий. Зөвхөн 2010 оныг авч үзэхэд тус парк 126 судалгааны ажлын төслийг шалгаруулж 114 сая ам.долларын санхүүжилт олгосон байна. Үүнд тавигдсан шаардлага нь төслийн багт дор хаяж нэг Катар улсад ажиллаж амьдардаг судлаач хүн оролцсон байх ёстой бөгөөд төрөөс дэмжлэг авсан санхүүжилтийн тал буюу түүнээс дээш хувийг Катар улсад зарцуулсан байх ёстой гэсэн хоёр зүйл байв.¹⁴⁶

Түүнчлэн, Катар орныг Арабын ертөнцийн боловсролын шинэ төв болгон хөгжүүлэхийг зорьж буй бөгөөд үүний нэгэн илрэл бол нийслэл Доха хотыг “Боловсролын хот” болгож буй явдал юм. Энэхүү бүтээн байгуулалттын ажилд эмирийн эхнэр Шейха Мозах чухал үүрэг гүйцэтгэж иржээ. Тэрээр дэлхийн шилдэг их сургуулиудын салбар сургуулийг эх орондоо авчрах төлөвлөгөө нь анх бүтэлгүйтэж байсан хэдий ч Катар улсын зүгээс хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээг (тодруулбал, барилгын ажил болон хүний нөөцийн зардлыг даах, өргөн цар хүрээтэй тэтгэлгийн хөтөлбөр нэвтрүүлэх г.м.) нэмж өгснөөр яриа хэлэлцээр эхнээсээ нааштай үр дүн авчирч өдгөө тус улсад АНУ-ын шилдэг зургаан сургууль, Европын холбооны хоёр сургуулийн¹⁴⁷ салбар тус тус үйл ажиллагаагаа явуулж байгаа аж. Вейл Корнеллийн анагаах ухааны коллеж гэхэд алдарт архитектор Арата Исозакигийн шилдэг бүтээл бүхий барилга дотор байрлаж, тэнд 80 гаруй судлаачид ажиллаж байгаа бол энэ тоо ойрын жилүүдэд 120 болон нэмэгдэх аж. Ийнхүү дэлхийн түвшний чанартай судалгаа хийх боломж бий болсноор анагаахын салбарт л гэхэд Ойрх Дорнодод тулгамдаад буй бүс нутгийн онцлогтой олон өвчин

¹⁴⁵ Ibid.

¹⁴⁶ Lublinski J. 2012. Katar klont Elite-Unis. Bild der Wissenschaft. http://www.wissenschaft.de/archiv/-/journal_content/56/12054/1630333/Katar-klont-Elite-Unis/

¹⁴⁷ University College London, HEC Paris

эмгэгээс ангижрах бодит гарц нээгдэж буй юм. Анагаах төдийгүй компьютер, инженерчлэлийн шинжлэх ухаан, кибер аюулгүй байдал, тогтвортой орчин судлал, тогтвортой эрчим хүч судлал, биологи, биохими гэх мэтчилэн олон салбарт өндөр зэрэглэлийн томоохон судалгааны лабораториуд ажиллах болсноор улс орны шинжлэх ухааны салбар цоо шинэ түвшинд буюу их гүрнүүдийнхтэй дөхөхүйц хэмжээнд хүрч очих үүд нээгдсэн байна. Ийнхүү Катарчууд дэлхийн судалгааны их гэр бүлд нэгдсэнээр зөвхөн Катар улс төдийгүй Арабын бүс нутаг тэр чигээрээ дэлхийн үсрэнгүй хөгжилтэй хөл нийлүүлэн алхах боломж бүрдэх билээ. Ийм орчинг бүрдүүлэхийн тулд Шейха Мозах бүхий л хүч чадлаа дайчлан ажиллаж байгаа аж. Тухайлбал, тэрээр 2010 онд ХБНГУ-ын нийслэлд айлчлан ирж Саксоны муж болон дэлхийд нэр хүндтэй Фрауэнхоферийн хүрээлэнтэй хамтарсан *Solar Carbon Black* төслийг хэрэгжүүлэх гэрээг байгуулсан байна. Энэ төсөл нь шинэ төрлийн технологиор ажиллах нарны эрчим хүч ашиглах шонгууд бүтээх тухай бөгөөд төслийн үр дүнд метан молекулуудыг нарны толиор дамжуулан 1500 хүртэлх хэмийн халуунд нүүрс болон хүчил төрөгч болгон задлах боломжтой болох юм. Тус технологи нь байгальд хортой нүүрс ус үүсгэхгүй давуу талтай бөгөөд шинээр гаргаж авсан нүүрсийг автомашины дугуй болон зай зэрэгт ашиглах боломжтой аж. Харин Катарын талд тус технологийг амьдралд хэрэгжүүлэхэд шаардлагатай эрдэмтдийн олон жил судлаад гацаанд ороод байсан нэгэн техникийн шийдлийг Дохад байрлах Тексас Эй энд Эм их сургуулийн профессор Нэсрин Өзалып амжилттай гаргаж авч чадсан байна. Энэ төсөл амжилттай хэрэгжсэнээр Катарын агаарыг их хэмжээний нүүрс ус ялгаруулан бохирдуулж буй томоохон аммиакийн үйлдвэрүүдийг орлуулах байгаль орчинд ээлтэй шийдэл болох аж.¹⁴⁸

Катарын хэтийн хөгжлийн тулгуурийг дэлхийн түвшний боловсрол хэмээн үзэж дунд сургуулийн боловсролоос өндөр зэрэглэлийн судалгааны түвшин хүртлэх өргөн цар хүрээтэй боловсролын шинэчлэлийн бодлого төр засгийн зүгээс цаг хугацааны хувьд дэлхийн хаа ч байхгүй их хурдаар хэрэгжүүлж байгаа явдлыг бүс нутаг талархан хүлээн авч буй юм. Энэ тухай шинжлэх ухааны салбарын нэрт сэтгүүлч Египет гаралтай Валийд Аль Шобакки ийнхүү дүгнэсэн байна:

“Улс төрчдийн зүгээс шинжлэх ухааны хөгжилд ихээхэн ач холбогдол өгч буйн үр дүнд нийгэмд удаан хугацааны турш хадгалагдан үлдэх гүн гүнзгий өөрчлөлтүүд гарах болно. Учир нь шинжлэх ухааны салбар ямагт илүү рационал буюу ухаалаг, илүү шүүмжлэлтэй бөгөөд илүү хараат бус хандлагыг ямагт дагуулж байдаг юм.” хэмээжээ.¹⁴⁹

¹⁴⁸ Lublinski J. 2012. Katar klont Elite-Unis. Bild der Wissenschaft. http://www.wissenschaft.de/archiv/-/journal_content/56/12054/1630333/Katar-klont-Elite-Unis/

¹⁴⁹ Ibid.

ДҮГНЭЛТ

Персийн булангийн бүс нутагт орших улс орнуудын онцлогийг нийгэм талаасаа исламын шашин дэлгэрсэн, улс төрийн талаасаа шашин төр хосолсон хаант засаглалтай, эдийн засаг талаасаа чинээлэг бөгөөд газрын тос, шатагч хийн арвин их нөөц баялагтай хэмээн ерөнхийд нь тодорхойлж болох юм. Эдгээр онцлог дээр тулгуурлан Катар улс нь өнгөрсөн зууны сүүлч буюу 1990-эд оны дунд үеэс эхлэн ирээдүйн хөгжлийн чиг хандлагаа тодорхойлж, түүнийхээ төлөө өдийг хүртэл тууштай хүчин зүтгэж буй улс орон юм.

Газрын тос буюу түүний үнийн хэлбэлзлээс шууд хараат эдийн засагтай тус улсын хувьд алсын хараагаа газрын баялагийн хүчин зүйлээс хараат бус, энтерпринёршип буюу бизнес эрхлэлт өндөр хөгжсөн, тогтвортой эдийн засагтай, дээд зэрэглэлийн боловсролтой, баян чинээлэг нийгэмтэй, бүрэн бүтэн экологийн системтэй орчин үеийн улс болгон хөгжүүлэхээр томъёолсон байна.

Энэ зорилгодоо хүрэхийн тулд тэд улс төр, нийгэм, эдийн засгийн томоохон өөрчлөлт, шинэчлэлүүдийг эхлүүлсэн бөгөөд их хэмжээний хөрөнгө оруулалтыг газрын баялгийн өгөөжөөр хийж ирсэн юм. Улс төрийн талбарт сайн засаглалын тухай хүн төрөлхтний түгээмэл тунхаглалд тусгагдсан хүчин зүйлсийг харгалзан үзэж улс төрийн тогтолцоогоо илүү либерал, илүү ардчилсан болгож хэмжээлшгүй эрхт хаант засаглалаас үндсэн хуульт хаант засаглалын тогтолцооруу шилжээд буй юм. Нийгмийн хөгжлийн талбарт улсын тэтгэмжээр “угжуулж” дассан “болхи” нийгмээс бизнес соёл өндөр хөгжсөн, баялаг бүтээгч баян чинээлэг нийгэмрүү шилжих суурь тавигдаж эхэлсэн ба энэ үйл явц нь хамгийн их цаг хугацаа шаардах аж. Нийгмийн энэхүү хөгжлийг дагаад эдийн засаг ч тогтвортой хөгжлийн голдрилд орох бөгөөд төр засгийн зүгээс эдийн засгийн үр ашигтай, солонгорсон хэлбэрийг хөхиүлэн дэмжиж ажиллаж байна.

Тус улсын хөгжилд тэмүүлэх их үйл явцад “тогтвортой” гэсэн ойлголт тэргүүн орой дээр ямагт заларч ирсэн нь тус улсын өдгөө олон улсад эзлэх нөлөө бүхий байр суурь, нэр хүндэд шууд хамаарна:

- Тогтвортой улс төр улс орны хөгжлийн их үндэс нь хэмээн үзэж улс төрөө тогтвортой байлгахын тулд гадна дотны аливаа нөлөөлөлд хариу үйлдэл үзүүлэх, дасан зохицох чадвар бүхий уян хатан стратегийг эрхэмлэж ирсэн байдаг. Тухайлбал, сөрөг хүчний эсрэг бодлого, нийгэмд нээлттэй ардчилсан бодлого, хүйсийн тэнцвэрт бодлого, глобалчлалын сөрөг нөлөөллийг багасгах бодлого, үндэсний үзлийг бэхжүүлэх бодлого зэргийн тунг тааруулж алсын хараатай хэрэгжүүлж ирсэний үр дүнд Арабын хаврын их үймээнээр нийгэм нь амар тайван байж, үүгээр төр засаг нь тогтвортой байдлаа хадгалан авч үлдэж чадсан юм. Тогтвортой улс төр нь гадны хөрөнгө оруулалт татах, гадаадад хувь нийлүүлэгч болох г.м. тус улсын макро эдийн засагт чухал үүрэг гүйцэтгээд зогсохгүй олон улсад эзлэх улс төрийн байр сууринд ч чухал нөлөө үзүүлж ирсэн хүчин зүйл юм. Улс төр тогтвортой

байдаг учир Катар хил орчмын маргаанаа Саудын Араб, Бахрейн улсуудтай эцэслэн шийдвэрлээд зогсохгүй идэвхтэй гадаад бодлогын үр дүнд бүс нутгийн олон маргаанд зуучлагчийн үүргийг амжилттай гүйцэтгэж, үүгээр их гүрнүүдтэй найрсаг сайн харилцаа тогтоож, улмаар олон улсад төвийг сахисан, энхтайванч имиж бүрдүүлж чадсан дунд гүрний статустай цөөн жижиг орны нэг болж чадсан юм.

- Тогтвортой эдийн засаг цогцлоох явдал тус улсын нэн тэргүүний зорилт бөгөөд энэ нь газрын баялгаас хараат бус, баялаг бүтээгч эдийн засагтай болох зорилт юм. “Катарын үндэсний алсын хараа 2030” баримт бичигт тусгагдснаар тус улс мэдлэгт суурилсан тогтвортой эдийн засгийг хөгжүүлэх юм. Үүний тулд, нэг талаас боловсролын өргөн цар хүрээтэй шинэчлэлийг хийж буй бөгөөд нөгөө талаас дэлхийн шилдэг судалгааны хүрээлэн, их сургуулиудтай бүс нутгийн онцлогт хамааралтай бүхий л салбарын судалгааны ажлууд дээр хамтран ажиллах, болж өгвөл тэдгээрийн салбар нэгжүүдийг эх орондоо нээн ажиллуулахад ихээхэн хөрөнгө мөнгө, цаг хугацаа шаардагдах ажлуудыг цаг алдалгүй хийж гүйцэтгэж байна.
- Тогтвортой хүрээлэн буй орчин нь улс орны цаашдын хөгжил цэцэглэлтийн бас нэгэн суурь үндэс юм. Уул уурхайн салбарын хөгжил, хүн амын хэт өсөлт зэрэг нь экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалах зүй ёсны шаардлага дагуулдаг учир энэ тал дээр анхаарч ажиллах нь Катарын үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Ирээдүйд уул уурхайн салбарыг орлох мэдлэгийн эдийн засгийн эрин үед ч байгаль орчинд халгүй, хүрээлэн буй орчныг тогтвортой байлгах шаардлага хэвээр байх учир Катарын судалгаа шинжилгээ инновацийн бодлого энэ талбарт онцгой ач холбогдол өгч буй нь тус улсад энэ чиглэлийн боловсон хүчин бэлтгэх, энэ чиглэлээр санхүүжилт авсан судалгааны төслүүд болон эрдэм шинжилгээний ажлуудаас тодорхой харагдана.

Цаашид Катар төдийгүй дэлхийн нийтийн хөгжлийн чиг хандлагад тогтвортой хөгжлийн судалгаа томоохон байр суурь эзлэх болсон явдал дэлхийд тэргүүлэх судалгааны байгууллагуудад энэ чиглэлээр шинжлэх ухааны түвшинд *sustainable development* буюу *sustainability science* хэмээн шинэ салбар үүсгэн судлах болсон, мөн бусад бүхий л салбарын мэргэжлүүд тогтвортой гэсэн тодотгол зүүх болсон зэргээс тодорхой харагдаж байна.¹⁵⁰

Монгол Улсын хувьд хөгжилд хөтлөх хэтийн зорилго, зорилтуудаа тодорхойлохдоо анх 1998 онд “Тогтвортой хөгжлийн бодлого”, 2008 онд “Мянганы зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” баримт бичгүүдийг баталсан байдаг. Хамгийн сүүлд 2016 оны 2-дугаар сард “Урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” баримт бичгийг баталсан бөгөөд үүгээр өмнөх хоёр

¹⁵⁰ The Sustainability Science Program at Harvard University's Center for International Development <https://www.hks.harvard.edu/centers/mrcbg/programs/sustsci>, The Sustainability Science and Policy programme <https://www.maastrichtuniversity.nl/education/master/master-science-sustainability-science-policy>

баримт бичиг хүчингүй болжээ.¹⁵¹ Монгол орны хэгийн хөгжлийг томъёолж ирсэн эдгээр баримт бичигт чухал байр суурь эзэлж буй тогтвортой хөгжлийн ойлголт нь НҮБ-ээс батлан гаргасан тогтвортой хөгжлийн үзэл санаанд суурилсан байдаг. Цаашид цаг тутамд хувьсан өөрчлөгдөж буй глобал орчинд энэхүү тогтвортой үзлийн үзэл санааг онолын түвшинд эх орныхоо хөрсөн дээр дэлгэрүүлэн судлан үзэх явдал чухал билээ.

Түүнчлэн, Монгол Улсын экспортын 1424.4 сая ам.доллар буюу 80.3 хувийг ашигт малтмалын бүтээгдэхүүн эзэлж буй явдал¹⁵² манай орныг “хуваарилагч улс”-ын онолын дагуу “бүрэн хуваарилагч орон”-ы ангилалд харьяалагдах болохыг илтгэнэ. Судлаачид газрын баялгийн арвин их нөөцтэй Ойрхи Дорнодын бүс нутгийн улс төр, нийгэм, эдийн засагт дүн шинжилгээ хийхдээ хуваарилагч орны онолыг түгээмэл ашигладаг бөгөөд энэхүү онолыг Монгол Улсын жишээн дээр дэлгэрүүлэн судлан үзэх бүрэн боломжтой юм.¹⁵³

¹⁵¹ Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай улсын их хурлын 19-дүгээр тогтоол <http://www.legalinfo.mn/law/details/11725>

¹⁵² Монгол улсын эдийн засгийн 2016 оны эхний 5 сарын байдал, Эдийн засгийн бодлогын газар <https://www.mof.gov.mn/wp-content/uploads/2016/07/2016-06-web.pdf>

¹⁵³ Мөн Д. Энхбат. Рентийн тогтолцоо ба улс төрийн намууд http://www.forum.mn/p_pdf.php?obj_id=4294 харьцуулна уу

НОМ ЗҮЙ

1. Ali Khalifa al-Kawari. 1996. tanmiya li-l-diya‘! Am diya’li-furas al-tan-miya. Muhassilat al-taghayyurat al-musahiba li-l-naft fi buldan majlis al-ta’awun [Алдагдалд хүргэсэн хөгжил! Юм уу хөгжих боломжыг алдсан явдал уу? ГХАЗ-ийн улс орнуудад газрын тосны үр дүнд гарсан өөрчлөлтүүдийн үр дагавар], Beirut
2. Mahdavy H. 1970. The Pattern and Problems of Economic Development in Rentier States: The Case of Iran in *Studies in the Economic History of the Middle East*, ed. M.A. Cook, Oxford: Oxford University Press
3. Нинжин, Г. 2014. Ойрхи Дорнодын Геополитикийн асуудалд: Бүс Нутаг дахь Хүчний Шинэ Төв Персийн Булан ба Монгол Улсаас Бүс Нутагт Баримтлах Улс Төрийн Байр Суурь. Магистрын зэрэг горилсон бүтээл, МУИС, ОУХНУС.
4. Perthes, V. 2005. Die Golfmonarchien Licht aus dem Osten? In: Geheime Gдrten. Die Neue Arabische Welt, pp. 348-367. Bonn: Bundeszentrale für politische Bildung
5. Ruf W., Marx Ch. 2012. Wandel in der arabischen Welt, LIT Verlag Mьnster
6. Cooper, Andrew F. 2015. Middle Powers: Squeezed out or Adaptive? Public Diplomacy Magazine.
7. Lambert J. 2011. Political Reform in Qatar: Participation, Legitimacy and Security. Middle East Policy Council
8. Lublinski J. 2012. Katar klont Elite-Unis. Bild der Wissenschaft. http://www.wissenschaft.de/archiv/-/journal_content/56/12054/1630333/Katar-klont-Elite-Unis/
9. Pawelka P. 1993. Der Vordere Orient und die internationale Politik. Stuttgart, 1993
10. Энхбат Д. Рентийн тогтолцоо ба улс төрийн намууд. Нээлтгэй нийгэм форум.
11. BP Amoco Statistical Review of World Energy 2000
12. National Development Planning and Implementation Human Development, Sustainable Development and National Well-being in Economic and Social Council Annual Ministerial Review 2014
13. United States Department of State Country Reports on Human Rights Practices for 2011: <http://www.state.gov/documents/organization/186656.pdf>
14. Wirtschaft von Qatar in <http://botschaft-katar.de/wirtschaft/wirtschaft-von-katar/>
15. Qatar Human Development in http://www.un.org/en/ecosoc/newfuncn/pdf14/qatar_nr.pdf
16. Qatar: Rise of an Underdog in <http://politicsandpolicy.org/article/qatar-rise-underdog>
17. Qatar Webster’s Timeline History 673 BC – 2007
18. “Qatar National Vision 2030”. Ministry of Development Planning and Statistics
19. Qatar National Development Strategy 2011-2016
20. The World Factbook, Central Intelligence Agency.
21. The Sustainability Science Program at Harvard University’s Center for International Development <https://www.hks.harvard.edu/centers/mrcbg/programs/sustsci>
22. The Sustainability Science and Policy programme <https://www.maastrichtuniversity.nl/education/master/master-science-sustainability-science-policy>
23. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай улсын их хурлын 19-дүгээр тогтоол <http://www.legalinfo.mn/law/details/11725>
24. Монгол улсын эдийн засгийн 2016 оны эхний 5 сарын байдал, Эдийн засгийн бодлогын газар <https://www.mof.gov.mn/wp-content/uploads/2016/07/2016-06-web.pdf>